

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 7 дугаар тэмдэглэлд:

“ХҮ.4. “Авто худалдааны цогцолбор”-ын үйл ажиллагааны өнөөгийн байдлын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан цаашид “Авто худалдааны цогцолбор”-ын үйл ажиллагааг тогтворжуулан, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд даалгав:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдад:

-Импортоор оруулж байгаа авто машины бүртгэлийг зөвхөн “Авто худалдааны цогцолбор” дахь Авто тээврийн үндэсний төвийн салбарт зохион байгуулах;

-Орон нутгийн зорчигч тээврийн вокзал (Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орших)-ыг 2018 оны II улиралд багтаан “Авто худалдааны цогцолбор”-т шилжүүлэн байршуулах асуудлыг судалж, холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх;

-Сонсголон өртөөнөөс Сонгино чиглэл (“Авто худалдааны цогцолбор” хүртэл 2.5 км)-ийн ашиглагдахгүй байгаа төмөр замыг сэргээн засварлаж, ашиглалтад оруулах боломжийг судлан шийдвэрлэх;

-Олон улсын тээвэр логистикийн болон төмөр замын ачиж буулгах төвийг “Авто худалдааны цогцолбор”-т байгуулах асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, саналаа 2018 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулах.


2. Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралтад:

“Авто машин, дагалдах сэлбэг хэрэгсэл болон бусад барааг гаалийн хяналт дор ачих, буулгах, шилжүүлэн ачих, хадгалах, тээвэрлэх гаалийн хяналтын бүсийг 2018 оны 4 дүгээр сард багтаан “Авто худалдааны цогцолбор”-т байгуулан, үйл ажиллагааг нь эхлүүлэх.

3. Нийслэлийн Засаг дарга С.Батболдод:

-“Авто худалдааны цогцолбор”-ыг цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны төвлөрсөн төвийн системд холбоход шаардагдах хөрөнгийг нийслэлийн төсөв болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх;

-“Авто худалдааны цогцолбор”-ын бүтээн байгуулалтад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг түлхүү татан оролцуулах чиглэл баримталж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР